

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2018.07.04

Өлгий.

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Үндэсний аудитын газраас 2017 онд төрийн аудитын байгууллагын хэмжээнд дэвшүүлсэн “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллалаа.

Аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогчоор батлуулан, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг нь зохион байгуулж ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд аудитын чиглэлээр 3 төрлийн 16, дотоод ажлын талаар 3 төрлийн 53, тусгай ажил үйлчилгээ 3 төрлийн 4 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Аудитын газар нь батлагдсан үндсэн 11 орон тоо, гэрээт 1 бүгд 12 орон тоогоор, 255,4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явууллаа. Тэргүүлэх аудитор аудитын менежер, аудиторуудтай төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ, үйлчилгээний ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.

Тайлангийн хугацаанд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу 1, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрсдийн саналаар 2 гүйцэтгэлийн аудит хийж, 204 төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг баталгаажуулж, эхний хагас жилд төлөвлөсөн аудитыг бүрэн хэрэгжүүллээ.

Аудитын дүнгээр нийтдээ 2538.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн үүнээс 2033,5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 66.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1460.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Аудитын дүнгээр нийт 35 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлснээс хэрэгжих хугацаа болсон зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж, хугацаа болоогүй 14 зөвлөмж дараагийн улиралд шилжлээ.

Эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт 23,8 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, актын биелэлт 36,0 хувьтай, 490,0 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулж, албан шаардлагын биелэлт 82,1 хувьтай тайлагнагдлаа. Төлбөрийн акт, санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрөөс нийт 63,6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулав.

Өмнөх оноос шилжин ирсэн 32,5 сая төгрөгийн 12 акт, 4 албан шаардлага, 12 заалт бүхий зөвлөмжийг бүртгэлд авч зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 100 хувь хангуулж, актын 73,2 хувийг барагдуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан байгууллагын 16 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг 100 хувь хангуулав.

Зөвлөмжийн үр дүнгээр 3498,3 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөж, төлбөрийн акт, санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн дүнгээр 72,1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлд тусгаж, хэрэгжилтийг тооцов.

Аймгийн аудитын газраас холбогдох хууль, журмын дагуу 13 төсөвт байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд аудит хараат бус аудитын 1 компани, 1 гэрээт аудитортой гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар.

Төрийн аудитын байгууллагын Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу аймгийн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтад хамрагдах 200 байгууллагын 241 санхүүгийн тайланд аудит хийхээс төсвийн шууд захирагч 108, тусгай сан 3, аж ахуйн нэгж 6, төвлөрүүлэн захирагч 15, төсвийн ерөнхийлөн захирагч 1 бүгд 133 нэгжийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагч 30, орон нутгийн 41 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 37 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн болно.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 119 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 13 санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгөв.

Аудитын дүнгээр нийтдээ 2330,3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 565,9 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд тусгуулан залруулж, 59,0 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1419,7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 285,7 сая төгрөгийн алдаа зөрчилд 26 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

Гүйцэтгэлээр 29,5 сая төгрөгийн актыг барагдуулж актын биелэлт 47,4 хувьтай, 1198,6 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулж 84,4 хувьтай, 21 зөвлөмжийн биелэлтийг хангуулж зөвлөмжийн биелэлт 80,8 хувьтай тайлагнагдлаа.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн 42,6 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой, 41,9 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 6,4 хувийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 9,1 хувийг бусад алдаа зөрчил эзэлж байна.

Аудитын дүнгээр хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан байгууллагын 16 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлэв.

Илэрсэн нийт алдаа зөрчлийн 1753,0 сая төгрөг буюу 75,2 хувь нь төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас, 64,3 сая төгрөг буюу 2,8 хувь нь аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангаас, 513,0 сая төгрөг буюу 22,0 хувь нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас тус тус илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа, зөрчлийг хураангуйлан харуулбал:

- Орон нутгийн харьяа төсөвт байгууллагуудын 2017 оны батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг нийт 4795.5 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 5023.5 хүн ажиллуулж орон тооны хязгаарыг 288 хүнээр хэтрүүлжээ. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 40.5 хүнээр, Боловсрол соёл урлагийн салбарын байгууллагууд 140 хүнээр, Эрүүл мэндийн салбарын

байгууллагууд 42.5 хүнээр, бусад байгууллагууд 5 хүнээр орон тоог хэтрүүлэн ажиллуулжээ.

- Орон нутгийн харьяа төсөвт байгууллагууд оны эцэст нийтдээ 1501.0 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 668.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 1053.1 сая төгрөгийн, Боловсрол соёл урлагийн салбарын байгууллагууд 388.2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 59.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
- Аймгийн Нийгмийн халамжийн сангийн дансны үлдэгдэл, санхүүжилтээс 2016 оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн 737,3 сая төгрөгийн хөрөнгийг буцаан олгоогүй, Нийгмийн халамжийн сангийн 2017 оны төсвийг үндэслэлгүй бууруулж баталсны улмаас оны эцэст нийт 948,3 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 350,4 сая төгрөгөөр нэмэгдэж, он дамжсан өртэй гарахад хүргэсэн байна.
- Цалингийн урьдчилгааны суутган тооцоог хийгээгүй, авлагыг тайланд тусгаж харуулаагүй, сахилгын шийтгэлтэй ажилтнуудад сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулал олгосон, ХХОАТ, НДШ-ийн тооцоогоор үүссэн өр, авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй, тайланд зөрүүтэй тусгасан, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, бараа материалын тайланг зохих журмаар гаргаагүй, түүнд нягтлан бодогч нь хяналт тавьж ажиллагаагүй, зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, жилийн эцэст тооллого хийсэн боловч тооцоог бодож, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, үнэ төлбөргүй олгосон бараа материал, хөрөнгийг орлого аваагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар хөрөнгө зарцуулсан, худалдан авсан бараа материалыг орлого авалгүйгээр нягтлан бодох бүртгэлд шууд зардлаар бүртгэж тайлагнасан зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрчээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаас илэрсэн зөрчлийн талаар:

- Ногооннуур сумын засаг дарга орон нутгийн төсөвт орох 4.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансаар дамжуулахгүйгээр ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулж, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, нэмэлт санхүүжилтээр тайлагнаж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж албан тушаалын эрх хэмжээг хэтрүүлжээ.
- Бугат сумын Засаг дарга агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 49.1 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд оруулахгүйгээр арилжааны банкинд зөвшөөрөлгүй данс нээж сумын ИТХурлын шийдвэр, Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан урсгал зардалд зарцуулан сумын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, нэмэлт санхүүжилтээр тайлагнаж Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж албан тушаалын эрх хэмжээгээ хэтрүүлжээ.
- Баяннуур сумын Засаг дарга Сум хөгжүүлэх сангаас "Уламжлалт ав" ХХК-д 5,0 сая төгрөгийг шилжүүлж, тооцоо хийж санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулжээ.
- Сумууд нь ОНХСан, Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэл, тооцоог санхүүгийн бус мэргэжилтнүүдэд хавсруулан гүйцэтгүүлж Засгийн

газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан нягтлан бодогч нарын ажлын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг зохих журмаар гаргаагүй зөрчил бүх сумуудаас нийтлэг гарсан байна. Энэхүү зөрчлийг арилгах талаар сумын Засаг дарга нарт албан бичгээр үүрэг өгөгдлөө.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Бугат, Ногооннуур сумын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, Бугат сумын төсвийн хууль тогтоомж зөрчиж зориулалт бус зарцуулсан 49.1 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүллээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хуулийн хугацаанд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг Засгийн газрын Э-тайлан цахим программд хянан баталгаажуулах ажил хангалтгүй хийгдэж, өмнөх онд энэ талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй хандсан байна. Санхүү төрийн сангийн хэлтсээс нэгтгэж ирүүлсэн санхүүгийн тайлангийн зарим тоо мэдээлэл аудит хийсэн санхүүгийн тайлангуудын нэгтгэлээс зөрүүтэй байснаас бүх байгууллага, сангуудын санхүүгийн тайланг Э-тайлантай нэг бүрчлэн тулгаж, зөрүүг арилгасан нь бидний ажилд ихээхэн хүндрэл учрууллаа.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад төсвийн хяналт, санхүүгийн тайланг гаргалт, бүртгэлийг сайжруулахад чиглэгдсэн 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэв.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар.

Тус Аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд 7 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсний 1 нь Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөт, 3 нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгат, 3 нь өөрсдийн саналаар хийх аудит байна.

Эхний хагас жилд Үндэсний аудитын газрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 1, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгаар 2, өөрсдийн саналаар 2 бүгд 5 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, аудитад 9 байгууллага хамрагдлаа. Гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 6 хүн ажиллаж, 142 хүн/өдөр зарцуулав.

Үндэсний аудитын газрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, тайланг хугацаанд хүргүүллээ. Гүйцэтгэлийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Эхний хагас жилд хийсэн аудитаар 207,7 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 7,0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 40,2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 160,5 сая төгрөгийн зөрчил дутагдлыг засахад чиглэгдсэн 9 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Тайланд хугацааны эцэст дүнг баталгаажуулсан аудитын зөвлөмж, акт, албан шаардлага дараагийн улиралд шилжиж байгаа нь барагдалтын хувь доогуур гарахад нөлөөлсөн болно.

Өмнөх оноос шилжиж ирсэн 6 зөвлөмж, 1 албан шаардлагын хэрэгжилтийг 100 хувь хангуулж, 16,9 сая төгрөгийн төлбөрийн актаас 2,8 сая төгрөгийг барагдуулж, 9,9 сая төгрөгийн 1 актыг хариуцагч байгууллага нэхэмжлэл гаргаж, шүүхэд шилжүүлснээр актын биелэлт 75,1 хувьтай гарлаа.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар.

Тус Аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд 4 нийцлийн аудит хийхээр төлөвлөсний 3 нь Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөт, 1 нь өөрсдийн саналаар хийх аудит байна.

Эхний хагас жилд өөрсдийн саналаар Аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа, нөөц хөрөнгө, давсан орлогын зарцуулалтад хийж байгаа нийцлийн аудит аудитын хамрах хүрээнээс шалтгаалж дараагийн улиралд шилжлээ. Нийцлийн аудитад 2 хүн ажиллаж, 24 хүн/өдөр зарцуулав.

Өмнөх оноос шилжиж ирсэн 6 зөвлөмж, 2 албан шаардлагын хэрэгжилтийг 100 хувь хангуулж, 12,3 сая төгрөгийн төлбөрийн актаас Нийгмийн халамжийн сантай холбоотой 10,0 сая төгрөгийн 2 актыг хариуцагч байгууллага нэхэмжлэл гаргаж, шүүхэд шилжүүлжээ.

Тав. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар.

2018 онд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгаар 3 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийхээс Эрүүл мэндийг газар, Татварын хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж дүнг баталгаажуулж, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэв.

2018 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өөрсдийн саналаар Орон нутгийн 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг баталгаажуулав.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр 5,4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8,4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 7 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Тайланд хугацааны эцэст дүнг баталгаажуулсан аудитын зөвлөмж, акт, албан шаардлага дараагийн улиралд шилжив.

Зургаа. Дотоод ажлын талаар.

6.1. Хүний нөөцийн ажлын талаар:

Тайлангийн хугацаанд батлагдсан үндсэн 11 орон тоо, гэрээт 1 бүгд 12 орон тоогоор ажиллаа. Санхүүгийн тайлангийн аудитын үеэр ажлын ачааллыг харгалзан 2 гэрээт ажилтан ажиллуулав. Хүний нөөцийн сарын мэдээг загвар маягтаар сар бүр гаргаж, Хүний нөөцийн албанд хүргүүлж ажиллаа.

Ахлах аудитор К.Риза 6 дугаар сарын 01-нээс өндөр насны тэтгэвэр гарч, оронд аудитор Д.Назгүлийн нэрийг дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар ахлах аудиторроор томилогдлоо.

Ахлах аудитор К.Ризаг “Алтан гадас одон”-оор шагнуулахаар тодорхойлж, холбогдох материалыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэв.

6.2. Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар:

Үндэсний аудитын газар болон бусад байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, и-мэйл нийт 284 албан бичгийг хүлээн авч бүртгэж, холбогдох ажилтнуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

Мөн байгууллагаас гарсан нийт 342 албан бичиг, дүгнэлтийг стандартын дагуу хэвлэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу хүргүүлжээ.

Дарга, тэргүүлэх аудиторын аудитын дүнг баталсан 3, хөрөнгө зарцуулахтай холбоотой 5, боловсон хүчинтэй холбоотой 8, бусад үйл

ажиллагаатай холбоотой 3 нийт 19 тушаал гаргаж бүртгэлд авч, хэрэгжилтийг хангуулав.

Удирдлагын зөвлөлийн хурлыг 3 удаа хуралдуулж санхүүгийн тайлангийн аудитын дүн, гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл хөтөлж албажуулав. Долоо хоногийн нэг дэх өдрийн өглөө бүр байгууллагын нийт ажилтнуудын өглөөний шуурхай хурлыг хийж, хурлын тэмдэглэл 20-ыг хөтөлж баримтжуулав.

Аудитын газрын ажлын тайлан, мэдээ болон санхүүгийн тайлангийн аудитын тайлангийн баримт материалуудыг хариуцсан аудиторуудаар ХХНЖ-ийн дагуу нэгжилт хийлгэж, архивын нэгж үүсгэн 136 мемориал баримт болгон үдүүлж, байгууллагын архивт шилжүүллээ.

Бүх ажилтнуудаас оны эхэнд нууцын баталгааг зохих журмын дагуу гаргуулан авч, баримтжуулав. Аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг ажилтнуудаар гаргуулж, баталгаажуулж байгаа ба санхүүгийн тайлангийн аудитаар ёс зүйн батламжийг давхар гаргуулан авч баримтжууллаа.

6.3. Мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар:

ҮАГ-ын audit.mn вэб сайтад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон бие даасан дүгнэлт гаргасан 132 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын тайлангуудыг байршуулж, аудитын болон цаг үеийн ажлын явцын талаар 19 мэдээ мэдээлэл тус тус бэлтгэж, байршуулав.

Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой бусад мэдээллийг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсанд байршуулж мэдээлж байна. Мөн аймгийн ИТХурал, Засаг дарга нарт аудитын тайланг санал зөвлөмжийн хамт хэвлэн хүргүүлж ажиллаа.

Байгууллагын мэдээллийн самбарт аудитын дүн, цаг үеийн ажлын талаар товч мэдээлэл бэлтгэж тогтмол байршуулж байна.

6.4. Сургалт, семинар, зөвлөгөөний талаар:

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны семинар, зөвлөгөөнд тэргүүлэх аудитор оролцлоо.

Үндэсний аудитын газраас 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 6 дугаар сард зохион байгуулсан шинэ ажилтны сургалтад аудитор Р.Баярмаа, худалдан авах ажиллагааны талаарх сургалтад аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл нар, менежерийн сургалтад аудитын менежер Х.Женисбек тус тус оролцлоо.

Аудитор Ж.Назгүл аймгийн Тагнуулын албанаас зохион байгуулсан төрийн болон албаны нууцын сургалтад хамрагдав. Аудитор Р.Баярмаа Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалт, шалгалтад хамрагдаж шалгалт өгч 4 хичээлд хөнгөлөлт авлаа.

Санхүүгийн тайлангийн аудитын сэдвээр аудитор, гэрээт аудиторуудыг хамруулж, 1 дүгээр сард 2 өдрийн сургалт зохион байгуулав. Үндэсний аудитын газрын сургалтууд давхацсан тул 6 дугаар сард хийхээр төлөвлөсөн Дотоод сургалтыг хойшлууллаа.

6.5. Бусад ажлын талаар:

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр Сум дундын ойн ангиас 5 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан мод тарих өдөрлөгт бүх

ажилтнуудыг хамруулж, онгоцны буудал явах зам дагуу байрлах мод үржүүлгийн газарт 20 ширхэг мод тарьж Сум дундын ойн ангид хүлээлгэн өгөв.

Байгууллагын ажилтнуудыг бүрэн хамруулж нэг өдрийн идэвхтэй амралт зохион байгууллаа.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Тайлангийн хугацаанд байгууллага, иргэдээс ирүүлсэн 4 өргөдөл гомдол, хүсэлтийг бүртгэлд авч, холбогдох ажилтнуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, 3 өргөдлийг шийдвэрлэж хариу өгч, 1 өргөдлийг завсрын аудитаар шалгах аар шийдвэрлэв.

Үндэсний аудитын газраас 2 өргөдлийг харьяаллын дагуу манайд шилжүүлснээс 1 өргөдлийг шалгаж дуусав.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.

7.1. Санхүүгийн тайлангийн талаар: Тус газарт 2018 оны хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгө 99,2 сая төгрөгийн, бараа материал 4,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төрийн сан дахь харилцах данс 4,1 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн харилцах данс 15,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарлаа. Хагас жилийн санхүүгийн тайлан эцэслэн гараагүй учраас санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн талаар бичих боломжгүй байна.

Хагас жилээр эд хөрөнгийн тооллогыг хийж, тооцоог бодож, актлах үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ТӨБЗГазраас зөвшөөрөл авч өгөх тухай албан бичгийг Үндэсний Аудитын газарт холбогдох материалуудын хамт хүргүүлсэн болно.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг гаргаж Үндэсний Аудитын газарт хүргүүлж ажиллав.

7.2. Төсвийн гүйцэтгэлийн талаар: Тус газрын 2018 оны үйл ажиллагаанд 255,3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилд 148,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 144,7 сая төгрөгийг зарцуулав.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл цалингийн зардалд 91,2 сая төгрөг, НДШ-д 10,6 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 1,4 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0,7 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 3,0 сая төгрөг, дотоод томилолтын зардалд 3,2 сая төгрөг, БҮТЭЗ худалдан авахад 0,2 сая төгрөг, хичээл дадлага, үйлдвэрлэлийн зардалд 0,5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 4,4 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 2,9 сая төгрөг тус тус зарцууллаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалын дагуу нэмэлт санхүүжилтээр 24,5 сая төгрөгийн санхүүжилтийг аудитын үйлчилгээний төлбөр, актын данснаас авч 4,5 сая төгрөгийг автомашины урсгал засварт, 2,5 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд, 1,0 сая төгрөгийг тээвэр, шатахууны зардалд, 0,8 сая төгрөгийг дотоод томилолтын зардалд тус тус зарцууллаа.

Найм. Дүгнэлт, санал

Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газар нь 2018 оны эхний хагас жилд Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон стандарт, журам зааврыг баримталж үйл ажиллагаагаа явууллаа.

Санал: Цаашид хагас, бүтэн жилийн ажлын тайлан, статистик мэдээг Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж, тайлагнах журамд заасан хугацаанд авч байх нь зүйтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН